

НЭГ СУДАЛТАЙ ЗЭС ДАМЖУУЛАГЧ БҮХИЙ 0.4 КВ-ЫН КАБЕЛИЙН ТЕХНИКИЙН ШААРДЛАГА

Техникийн тодорхойлолт:

Энэхүү техникийн тодорхойлолтыг VDE0250, BS EN/IEC 60332-1 стандартын дагуу үйлдвэрлэсэн 1 фазын цагаан тугалгаар бүрсэн уян зэс судалтай, EPR (3G13 төрлийн этилен пропиленийн резин) тусгаарлага бүхий PCP (5GM5 төрлийн полихлорпрен) бүрээстэй 1.8/3 кВ-ын хүчний кабелийг УБЦТС ТӨХК-д худалдан авах үед хэрэглэнэ. Хийц болон гадар диаметрийн үзүүлэлтийг 1 судалтай 240 мм² 150 мм² хөндлөн огтлолтой 1.8/3 кВ-ын хүчний кабелийн хувьд заасан ба бусад ижил хөндлөн огтлолтой ижил марктай кабель худалдан авах үед дамжуулагч утасны тоо хөндлөн огтлолоос бусад кабелийн хийц тусгаарлага бүтэц нь энэхүү шаардлагад тусгасан үзүүлэлттэй ижил байх шаардлагатай. Ижил маркийн жижиг хөндлөн огтлолтой кабелийн дамжуулагч судал дахь утасны тоо болон хөндлөн огтлол VDE0250, BS EN/IEC 60332-1 стандартын дагуу байх шаардлагатай.

Орчны нөхцөл

Тос нэвтрүүлдэггүй нэг судалтай кабелийг хуваарилах самбар, тоног төхөөрөмжийг холбоход хэрэглэдэг зориулалтын байна. Гадаа суурил

1. Шинж чанар, үзүүлэлт

Хүчдлийн үзүүлэлт (U₀/U)

1.8/3 кВ

Ажиллах температурын үзүүлэлт

Тогтмол: -40°C-өөс +90°C /Дамжуулагчийн ашиглалтын хамгийн бага ба их температур/

Хувьсах: -25°C өөс +90°C /Дамжуулагчийн угсралтын үеийн хамгийн бага болон их температур/

Хамгийн бага муруйлтын радиус

Тогтмол: 4 x overall diameter /Кабелийн хамгийн бага муруйлтын радиусыг 4*D байхаар тооцно/

Хувьсах: 5 x overall diameter / Кабелийн хамгийн бага муруйлтын радиусыг 5*D байхаар тооцно/

Бүрээсний өнгө

Хар

2. Кабелийн бүтэц

Дамжуулагч

Цагаан тугалгаар бүрсэн уян зэс кабель, зэрэглэлт 5

Тусгаарлага

3G13 төрлийн этилен пропиленийн резин (EPR) байна. DIN VDE 0207 стандартын дагуу

Гадна бүрээс

5GM5 төрлийн полихлорпрен (PCP) байна. DIN VDE 0207 стандартын дагуу

NSGAFOU кабелийн гадна бүрээс нь гал удаашруулах ба тос нэвтрүүлдэггүй, хэт ягаан туяаны хамгаалалттай.



Дамжуулагч	Цагаан тугалгаар бүрсэн уян зэс кабель, (Зэрэглэл 5)
Тусгаарлага	Этилен пропиленийн резин (EPR), Төрөл: 3G13
Гадна бүрээс	Полихлорпрен (PCP), Төрөл: 5GM5

3. Кабелийн хэмжээснүүд

Судлын тоо	Дамжуулагчийн хөндлөн огтлолын /мм ² /	Тусгаарлагчийн хэвийн зузаан /мм/	Бүрээсний хэвийн зузаан /мм/	Ерөнхий диаметр /мм/		Хэвийн жин Кг/км
				Хамгийн бага	Хамгийн их	
1	150	2.2	1.2	21.7	24.7	1581
1	240	2.6	1.2	26.3	29.7	2452

4. Дамжуулагч

Нэг судалтай болон олон судалтай уян зэс дамжуулагч, Зэрэглэл-5

Дамжуулагчийн хөндлөн огтлол /мм ² /	Дамжуулагч утасны хамгийн их диаметр /мм/	Дамжуулагчийн хамгийн их эсэргүүцэл 20°C-д
		Метал-бүрсэн утас /ом/км/
150	0.51	0.132
240	0.51	0.0817

Дээрх хүснэгтэд тусгагдсан үзүүлэлт нь BS EN 60228 (өмнөх хувилбар нь BS 6360) стандартын дагуу байна.

5. Цахилгааны үзүүлэлт

Ачаалал нэвтрүүлэх чадвар

Дамжуулагчийн хөндлөн огтлол /мм ² /	Ачаалал нэвтрүүлэх чадвар	
	Агаарт /А/	Сувагт /А/
150	566	301
240	775	412

Орчны температур 30°C байх ба 90°C-д дамжуулагч хална.

Туршилтууд

Туршилтууд нь “ТШТ: ЕШН Техникийн ерөнхий шаардлага ба нөхцөл”-ийн дагуу хийгдсэн байх ёстой.

Уг нийлүүлэх зэс кабель нь VDE0250, BS EN/IEC 60332-1 стандартын

шаардлагыг хангасан сертификат заавал ирүүлсэн байна. Дээрх үзүүлэлтүүдийг нотолсон үйлдвэрлэгчийн хэмжилт туршилт, мөн хөндлөнгийн үл хамаарах лабораторын баталгаат туршилтын бичиг заавал ирүүлсэн байна. Дээрх сертификат, туршилтын бичгийг хамтад нь хүчинтэйд тооцно. Нийлүүлэхээр санал болгож буй кабелийн загвар ирүүлнэ.

Ашиглалтын нөхцөл

Ашиглалтын нөхцөл нь “ТШТ: ЕШН Техникийн ерөнхий шаардлага ба нөхцөл”-ийн “24. Орчны нөхцөл”-д шаардлагад нийцсэн байх ёстой. / tog.mn /хууль дүрэм журам / Бичиг баримтууд 12, 24